

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Хичээлийн жил дуусахад гурван долоо хоног үлдсэн ч энэ хугацаанд олон арга хэмжээ зохиогдоно. 12-р ангийн сурагчид маань шалгалтуудаа дуусч төгсөлтийн баяртаа бэлтгэж байна. 5-р ангийн сурагчид үзэсгэлэндээ бэлтгэж байна. Бид энэ хугацаанд манай сурагчдын авъяас чадварыг харуулсан олон арга хэмжээнүүдийг зохиогоод байна.

5 сарын 21-ний Баасан гарагт бид Авъяастнуудын тоглолт, үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд оролцсон олон хүмүүс манай сурагчдын авъяас чадварыг өндөр үнэлж байсан. Бидэнтэй өөрсдийн авъяасыг хуваалцсан сурагчиддаа баярлалаа. Энэ арга хэмжээг амжилттай зохион байгуулсан багш нартаа баярлалаа.

Энэ хичээлийн жилийн “Захирлын Өглөөний Кофе” төгсгөлийн уулзалт 5 сарын 21-ний өглөө болсон. Бид энэ уулзалтын үеэр эцэг эхчүүдтэй цай кофе ууж амттан идэнгээ санал бодлоо солилцдог уламжлалтай. Манай уулзалтанд ирж оролцсон эцэг эхчүүддээ баярлалаа. Би энэ уулзалтыг ирэх хичээлийн жилд үргэлжлүүлэн хийх болно. Бид улиралд нэг удаа энэ уулзалтыг зохион байгуулдаг. Та бүхэн ирэх жил манай энэ уулзалтанд ирж оролцоорой.

Ирэх жилийн эсэлтийн мэдээллүүд та бүхэнд очсон байгаа. Та бүхэн төлбөр, хураамжаа цагт нь төлж хүүхдийнхээ сурах орон тоог баталгаажуулаарай. Сургалтын төлбөрийг төлөх хугацаа 2010 оны 8 сарын 1. Та бүхэн дэлгэрэнгүй мэдээллийг манай Санхүүгийн ажилтнуудтай холбоо барьж аваарай.

Хичээлийн жил дуусахтай холбогдуулан зарим сурагчдын сурах идэвх чармайлт бас сулрах хандлагатай болдог. Хичээлийн жилээ амжилттай дуусгахын төлөө идэвхтэй чармайн суралцахад нь та бүхэн хүүхдүүддээ урам өгч дэмжээрэй.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

5 сарын 28	Төгсөлтийн Баяр
5 сарын 29	Төгсөлтийн Үдэшлэг
6 сарын 1	Хүүхдийн Баяр-Нийтээр амрах баярын өдөр
6 сарын 2-4	4-р ангийн Кемп аялал
6 сарын 8	5-р ангийн Үзэсгэлэн
6 сарын 10-11	3-р ангийн Кемп аялал
6 сарын 10-12	5-р ангийн Кемп аялал

2010-2011 оны хичээлийн жилийн элсэлтийн талаар

Капитал фондын төлбөр болон элсэлтийн хураамжийг 2010 оны 6 сарын 1-ний дотор төлж хүүхдийнхээ ОУДС-д эргэн ирж суралцах орон тоог баталгаажуулна уу.

2010-2011 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн нэхэмжлэлийг та бүхэнд удахгүй илгээх болно. Та бүхэн хүүхдийнхээ сургалтын төлбөрийг 8-1-ний дотор хугацаанд нь төлөөрэй.

Баасан гарагийн орой ирж **Авъяастнуудын тоглолт, бүтээлийн үзэсгэлэнг** сонирхсон хүмүүс манай сурагчдыг их авъяаслаг, бүтээлч хүүхдүүд гэдэгтэй санал нийлэх байх гэж би найдаж байна. Ms. Leong, Ms. Sudra, Сарантунгаа, Mrs. Jenner, Mrs. Berg, Ууганбаяр нарт болон энэ арга хэмжээг зохион байгуулахад тусалсан бусад хүмүүст баяр хүргэе. Мөн жигнэмэгийн худалдаа зохион байгуулсан ЭББ-ийн хамт олонд баярлалаа. Бид сурагчдын бүтээлүүдийг эмхтгэж ном болгож хэвлүүлсэн. Энэ номыг захиалах хуудсыг Мэдээнд хавсаргаж та бүхэнд явууллаа.

“Уран Зургийн Боловсрол Үзэсгэлэн” Уран Зургийн Галерейд 6 сарын 1-нд гарна. Тус музейд зочлохдоо 4,5-р ангийн сурагчдын зурсан бүтээлүүд энэ үзэсгэлэнд тавигдана.

Англи Хэлний Зуны Зуслан

Хэрвээ хүүхэд тань зуны амралтаараа Улаанбаатарт байж англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх сонирхолтой байгаа бол Америк сургууль дээр 6 сарын 21-7 сарын 9-ний хооронд зохиогдох Англи хэлний зуны зусланд бүртгүүлээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг 348888 дугаараар Амраатай холбогдож авч болох буюу www.asu.edu.mn вэб сайтаас авч болно.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Төгсөх ангийн сурагчид маань шалгалтуудаа өгч дууслаа. Бид та бүхнээр бахархаж байгаа бөгөөд та нарын нэгэн адил Баасан гарагийн орой болох Төгсөлтийн баярыг тань сэтгэл догдлон хүлээж байна. Төгсөлтийн баяр баасан гарагт орой 7:30-с сургуулийн заланд болно. Та бүхнийг урьж байна.

Бямба гарагийн орой ахлах ангийн сурагчдын Төгсөлтийн Үдэшлэг болно. Үдэшлэгийн дараа 23 цагт хүүхдүүдээ тарахад нь хоцролгүй ирж аваарай. Үдэшлэг Калифорния рестораны Regency Ballroom-д болно.

Та бүхэн хүүхдүүдээ ус сайн ууж, хоол сайн идэж, унтаж амрахад нь сайтар анхаараарай. Хичээлийн жилийн төгсгөлд стресст орох байдал элбэг гардаг тул үүнийг давж гарах хамгийн сайн арга нь эрүүл байх явдал юм.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Цаг агаар дулаан тааламжтай байгаад бага сургуулийн хамт олон бид баяртай байна. Өнгөрсөн Баасан гарагт 1-р ангийн сурагчид маань шавьж хорхой судлах аялал хийгээд ирлээ. Тэд хаврын анхны цэцэгсийг харж хоол идэх зуураа бэлчиж байгаа үхэр сүрэгтэй тааралдсан.

5-р ангийн сурагчид маань Баян Зүрх дүүргийн асрамжийн хүүхдүүдтэй сургуулийнхаа найзуудыг аваачиж хамт тоглуулах ажлыг зохион байгуулж байна. Сурагчид маань өөрсдийн цагаас бусдад зориулах нь бусдын амьдралыг хэрхэн өөрчилж чадах талаар суралцлаа. Dolma Ling Халамжийн Төвийн настангуудад зориулж цуглуулсан хандивын гурил будаагаа 5-р ангийн сурагчид энэ долоо хоногт тэдэнд хүргэж өглөө. Энэ хандивын арга хэмжээнд оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Дуу хөгжмийн хичээлээр бага сургуулийн сурагчид маань багш Сарантунгаагийн хамт бэсрэг хөгжимт жүжгийн тоглолтуудыг бэлтгэж бидэнд сонирхуулж байгаа. Энэ долоо хоногт бэлтгэл ангийн сурагчид “The Little Red Hen”, 1-р ангийн сурагчид “The Three Piggy Opera” тоглолтуудыг бидэнд сонирхууллаа.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins

Номын санчид хичээлийн жилийн төгсгөлийн тооллогоо хийх тул ОУДС-ийн номын Сан 6 сарын 4-с эхлэн хааж ном олгохгүй. Ангиуд хуваарьт цагийн дагуу номын санд хичээллэж болох боловч 6 сарын 4-с эхлэн сурагчид, эцэг эхчүүдэд ном олгохгүй. Хичээлийн номноос гадуурх бусад Номын сангийн бүх ном, хэвлэл, сэтгүүлийг та бүхэн 6 сарын 4-ний Баасан гарагт багтаан бидэнд буцааж хураалгана уу. Та бүхэн гэртээ номын сангийн ном үлдээлгүй сайн шалгаарай. Алга болгосон номын үнийг сурагчдын номын сангийн урьдчилгаа төлбөрөөс суутгаж авах болно.

Та бүхэнд баярлалаа.

Номын Санч Michele Moller